

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
395 дугаар тогтоолын 18 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Газар зохион байгуулалт, геодези,  
зураг зүйн газар

Геодези, зураг зүйн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Байнгын ажиллагаатай суурин станц  
хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 3

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байнгын ажиллагаатай станцийн /GNSS/  
сүлжээ байгуулах, нарийвчлалыг сайжруулах, геодезийн байрлалын тулгуур сүлжээний  
нэгдмэл байдлыг хангах.

Албан тушаалын зорилт:

1. Геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлого, Монгол Улсын эдийн засаг,  
нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын уйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний

хэмжээний урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад геодези, зураг зүйн чиглэлээр санал өгөх, хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахб

2. Байнгын ажиллагаатай станц байгуулах, шинэчлэх, өтгөрүүлэх, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэглэгчдэд бодит агшны RTK засвар тараах боломжийг бурдуулэх.

3. Геодези, зураг зүйн мэргэжлийн боловсон хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох, байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

4. Хэрэглэгчийг GNSS-ийн сүлжээний мэдээллээр хангаж, олон нийтийг бодит агшны RTK засвараар хангах ажлыг сурталчилах, ажлыг зохион байгуулах.

5. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар дэмжлэг үзүүлж ажиллах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад геодези, зураг зүйн чиглэлээр санал өгөх, хэрэгжүүлэх;</p> <p>2. GNSS-ийн сүлжээний талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэх, орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулах;</p> <p>3. Салбарын урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд GNSS-ийн сүлжээний талаар тусгах арга хэмжээг боловсруулах, санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд GNSS-ийн сүлжээний чиглэлийн арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг хангах;</p> <p>5. Геодези, зураг зүйн хууль болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх;</p> <p>6. Геодези, зураг зүйн чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг</p>	<p>Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.</p> <p>Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.</p> <p>Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна.</p> <p>Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна.</p> <p>Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.</p> <p>Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>



	зохион байгуулах.	уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.	
2 дугаар зорилтын хурээнд	1.GNSS-ийн байнгын ажиллагаатай станц байгуулах, нарийвчлалыг сайжруулах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;	Байрлалын сүлжээний нэгдсэн байдал хангагдсан байна.	Г
	2.GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын өдөр тутмын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, байнгын ажиллагаатай станцын хадгалалт хамгаалалт, засвар арчилгаа, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын, хэвийн үйл ажиллагаа хангагдаж, хяналт тавигдсан байна.	Г
	3.GNSS-ийн байнгын ажиллагаатай станцыг байрлалын сүлжээтэй нийцүүлэн жилд 2-оос доошгүй удаа тэгшигтгэн бodoх;	Байрлалын сүлжээний нарийвчлал сайжирсан байна.	Г
	4.GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын өгөгдлийн зохион байгуулалтыг хийж, өгөгдөл чанарын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах;	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын солбицол, RTK засварын үнэн зөв өгөгдлөөр хэрэглэгч хангагдсан байна.	Г
	5.Монгол Улсын хилийг зурагжуулах, Монгол улсын нутаг дэвсгэрийн газрын сан нэгдмэл байх нөхцлийг геодезийн хэмжил зүйгээр баталгаажуулах ажлыг зохион байгуулахад оролцох;	Улсын болон аймаг, сумын хилийн солбицолжуулж, баталгаажуулсан байна.	Г
	6.GNSS-ийн байнгын ажиллагаатай станц байгуулах, шинэчлэх ажил технологи, нарийвчлалын шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах;	Улсын төсвөөр хийгдэж буй ажлууд шалгагдсан, улсын нэгдсэн санд хүлээлгэж бүртгэгдсэн байна.	Г
	7.GNSS-ийн байнгын ажиллагаатай станц байгуулах, шинэчлэх, байнгын үйл ажиллагааг хангах чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах санал боловсруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Төсөл, хөтөлбериийн хэмжээнд хийгдэж буй үйл ажиллагаа давхардахгүй, хууль тогтоомжийн хурээнд хэрэгжих.	Г
	8.GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын гео орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх, өгөгдөл, мэдээлэл шинэчлэх ажлыг зохион байгуулах.	Мэдээллийн сангиин өгөгдөл, мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Г



3 дугаар зорилтын хүрээнд	1.Геодезийн мэргэжлийн боловсон хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох, сургалтын төлөвлөгөөнд санал өгөх;	Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхи дээшилсэн байна.	Г
	2.GNSS-ийн чиглэлээр хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг хэрэгжүүлэх;	Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхи дээшилсэн байна.	Г
	3.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага болон бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.	Бусад салбар геодези, зураг зүйн чиглэлээр ойлголт мэдлэгтэй болсон байна.	Г
	4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн териин захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй тесөл, хөтөлбөрт геодези, зураг зүй, хаягжуулалтын чиглэлээр хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Улсын хэмжээнд GNSS-ийн сүлжээний мэдээллийн нэгдсэн санг байгуулж, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бурдуулэх;	Орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан байна.	Г
	2. GNSS-ийн сүлжээний мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, зөвлөмж, дүгнэлт гаргах;	Холбогдох журмын дагуу үйлчилгээнд гаргасан байна.	Г
	3.Улсын хэмжээнд GNSS-ийн сүлжээний чиглэлээр хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй тесөл, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүн, мэдээллийн сангийн талаар олон нийтэд сурталчилах.	Олон нийтийг зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
5 дугаар	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дотоод ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, тесөвт тусгуулах санал боловсруулж, нэгжийн даргад танилцуулан, хэрэгжилтийг хангах;	Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байна.	Г
	3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргад танилцуулах, батлуулах, хэрэгжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
	4.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Гүйцэтгэлийн	Г



зорилтын хүрээнд	биелэлтийг сар, улирал, хагас жилээр гаргаж нэгжийн даргад тайлагнах;	төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	
	5.Үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
	6.Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг хангах;	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Г
	7.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байна.	Г
	8.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хулээлгэн өгөх;	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	Г
	9.Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох.	Хамрагдсан хурал, уулзалт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Боловсрол	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	-Геодези /0532-01/ /геодези, инженер геодези, сансрын геодези-астрономи, геодезийн мэдээлэл зүй, агаарын зураглал/		
Мэргэшил	-Тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх /байрлалын сүлжээ, тэгшигтэн бодолтын чиглэлээр/		
Туршлага	-Туслах түшмэлийн албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглувалж, дүгнэх; -мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн дүн шинжилгээ хийх; - судалгаанаас гарсан үр дүнг тухайн сэдвээр өмнө хийсэн судалгааны ажлын үр дүнтэй харьцуулж дүгнэлт гаргах;	
	Асуудал шийдвэрлэх	-албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дунд хяналт тавьж чаддаг	

		<p>байх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- үүссэн асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг сонгох;</li> <li>- санаачлагатай байж, бүтээлчээр уриалан чиглүүлэх;</li> <li>- нөөц боломж, эрч хүчээ дайчлахад нь дэмжлэг үзүүлэх;</li> <li>- хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, халамжлах зэргээр үлгэрлэх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай байх;</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-autocad, arcgis, bernese, geocalc, gnss-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг бүрэн эзэмшсэн;</li> <li>-геодезийн хэмжилтийн бүх төрлийн багаж, 2 долгионы gps дээр ажиллах бүрэн чадвартай байх;</li> <li>-геодезийн хэмжилт, зураглалын боловсруулалт, байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээний хэмжсэн болон тэгшигэсэн утгад нарийвчлалын үнэлгээ, дүн шинжилгээ хийх, солбицлын систем болон эрин хоорондын хөрвүүлэлтийг хийх ур чадвартай байх;</li> <li>-англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын орлогч дарга
- Нэгжийн дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
2. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
3. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:



Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

..... А.БАТБАЯР

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн  
нэр)

9128921 1117149041

2019 оны 12 сарын 25-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19.12.25

Дугаар: 395

**VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.12.27

Дугаар:

391


(тамга/тэмдэг)

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр



Ц.ГАНХҮҮ

